



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 11-ны өдөр

Дугаар А/124

Эрдэнэт

Гэрийн эргэлтэд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн сайдын 2020 оны Томуу томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай 482 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сум, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үзлэгийг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулах зорилгоор 11 дүгээр сарын 12-оос эхлэн 0-5 нас, жирэмсэн, дархлаажуулалт, 65-аас дээш нас, архаг хууч өвчтэй эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх тусламж үйлчилгээг гэрийн эргэлтэд шилжүүлсүгэй.


2. ЭМС-ын 2020 оны А/482 тоот тушаалаар батлагдсан "Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж"-ийн дагуу төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжилтийг хангах, ЭМС-ын 2018 оны А/527 дугаар тушаалын дагуу халдварт өвчний сэжигтэй болон өвөрмөц тохиолдол, ДДУХ-ыг анх үзсэн эмч, эмнэлгийн ажилтан босго үзүүлэлтийн дагуу 2019 оны А/611 тушаалын АМ-2 маягтаар мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллах

3. Амьсгалын замын халдварын үзлэгийн өрөө, хүлээлгийн хэсгийг тусад нь зохион байгуулж эрэмбэлэн ангилах хөтөч ажилтанг томилох, томуу, томуу төст өвчин, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хүн амын дунд эрчимтэй зохион байгуулах

4. Хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж, хүний нөөцийн судалгааг тодотгон томуу, томуу төст өвчний үе шат бүрт тохирсон тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг тус тус хэрэгжүүлж ажиллахыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн / Г.Энхжаргал/ -д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ